



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээ, гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	6
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	7
Ахлах аудитор Т.Намжил	Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа ч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.	9
Аудитор Б.Одгэрэл Т.Амармэнд	А.1. Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байгаа ч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.	9
2022 оны 4 дүгээр сар	А.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээг Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.	9
	А.1.2. Жагсаалтад батлагдсан хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээг баталсан байна.	11
	А.1.3. Төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн байна.	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлсэн ч хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.	13
	А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 2 төсөл, арга хэмжээг төсөвлөж батлуулсан байна.	13
	А.2.2. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна.	14
	А.2.3. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төсвийн тодотголоор төлөвлөж, батлуулсан байна.	16
Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Б.2. Гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна	17
	Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулжээ.	17
	Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.	17
	Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан байна.	18
	Б.1.3. ХАА-г ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулсан байна.	19
		20

Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.	20
Б.2. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.	20
Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлсэн боловч гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.	21
Б.2.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.	22
Б.2.3. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн байна.	22
Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	22
Б.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна.	22
Б.3.1 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.	24
Б.3.2. Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгасан, улирлын байдлаас шалтгаалан зарим төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхлээгүй байна.	24
Б.4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.	25
Дүгнэлт	26
Холбогдох байгууллагын санал	29
Аудитын газраас өгөх тайлбар	30
Зөвлөмж	

Товчилсон үгийн тайлал:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үзүүлэлт
ХАА	Худалдан авах ажиллагаа



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дүгээр А/18

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 5 дугаар хавсралт, 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг /УВА-2022/16-19/02-ШТА-ГА/ хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ажлах аудитор Т.Намжил нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  БАТСУУРЬ



0200100085

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Нийслэл дахь Төрийн аудитын газар, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг 2021 онд санхүүжүүлэхээр баталсан Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 9, Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 1, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн 7, нийт 17 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт болон гэрээний хэрэгжилтэд аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Аудитад аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулсан.

Арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817-8:2020, “Төрийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын аудит хийх журам, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын арга зүйгээр хангаж, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Намжил, аудитор Б.Одгэрэл, Т.Амармэнд нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын хүрээнд аймгийн төвийн сум болон хөдөөгийн 3 суманд очиж ажилласан бөгөөд төсөл хөтөлбөрийн эрх шилжин хэрэгжсэн 4 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид очиж ажилласан болно.

Аудитын дүн

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 5 зөвлөмж өглөө.

Ерөнхий зүйл

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг анх аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03/04 дүгээр тогтоолоор баталж, 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор тодотгол хийсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 789.8 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ, аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 258.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгөөр 345.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, нийт 1393.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Хэрэгжүүлэх хугацааны хувьд дээрх 17 төсөл, арга хэмжээнүүд бүгд 2021 онд хэрэгжүүлэхээр байна.

БҮЛЭГ: 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа ч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөн батлуулсан байна.

А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөж, зохистой арга хэмжээг авч байгаа ч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.

А.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээг Увс аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1 дэх хэсэгт "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална" гэж заасан байна.

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
- 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.4.тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
- 5.1.5.тэнцвэртэй байх;
- 5.1.6.нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;
- 5.1.7.ил тод, нээлттэй байх;
- 5.1.8.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.9.зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
- 5.1.10.шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;
- 5.1.11.төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;
- 5.1.12.төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;
- 5.1.13.бүх талын оролцоог хангасан байх;
- 5.1.14.төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;
- 5.1.15.оролцогчдын хариуцлагын зарчим.
- 5.1.16.нэгтгэн тайлагнах зарчим;
- 5.1.17.төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар 789.8 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ, аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 258.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгөөр 345.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, нийт 1,393.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 17 төсөл, арга хэмжээнээс 16 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчим, аймгийн Хөгжлийн

стратеги төлөвлөгөө /2008-2021/, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлогод нийцэж байна. Үүнд:

Д/д	Бодлогын баримт бичиг	Бүлгийн агуулга
1	Аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/-д аймгийн хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж 5 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	- Хүн ам, нийгмийн хөгжлийн бодлого - Эдийн засгийн хөгжлийн бодлого - Байгаль орчны хөгжлийн бодлого - Нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого, зохицуулалт - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг арга хэрэгсэл
2	Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого - Хүний хөгжлийн бодлого - Эдийн засгийн бодлого - Засаглалын бодлого - Ногоон хөгжлийн бодлого - Бүс, сум, орон нутгийн хөгжлийн бодлого
3	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 8 бүлэг болгон баталсанд нийцэж байна.	- Үндэсний нэгдмэл үнэт зүйл - Хүний хөгжил - Амьдралын чанар ба дундаж давхарга - Эдийн засаг - Засаглал - Ногоон хөгжил - Амар тайван, аюулгүй нийгэм - Бүс, сум, орон нутгийн хөгжил

Харин Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан Мини захын дэнчинг “Ус рашаан Эрдэнэ” ХХК-д буцаан олгох 18.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчим, аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлогод нийцэхгүй байна.

“Ус рашаан Эрдэнэ” ХХК-тай аймгийн ИТХ-ын 2014 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/49 тоот тогтоолоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба Улаангом суманд байрлах хүнсний худалдааны “Мини зах”-ыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах тухай гэрээг байгуулан уг захыг шилжүүлжээ. Тухайн компани нь барьцаанд 20.6 сая төгрөгийг төрийн сангийн 100150051401 дансанд байршуулсан байна.

Улмаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас менежментийн гэрээний үүргийг хангалтгүй биелүүлсэн гэж үзэн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/166 дугаар тогтоолоор менежментийн гэрээг цуцалж, дэнчинг улсын орлого болгосон байна.

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 28 дугаар магадлал гарч аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/76 дугаар “Мини захын менежментийн хувьчлалын нэгдсэн тайлан дүгнэх тухай” тогтоол гарч, ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/77 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргад чиглэл хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А/528 дугаар захирамж гарч санхүүжилтийг буцаан олгосон байна.

А.1.2 Жагсаалтад батлагдсан хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй 1 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.2.3 дахь заалтад “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 6.2.6 дахь заалтад “Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар бол доор дурдсан зохицуулалт хийнэ”, 6.2.6.а-д “тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх” гэж заажээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/04 дүгээр тогтоолоор аймгийн 2021 оны төсөв батлахдаа орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 төсөл, арга хэмжээ, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 1 төсөл, арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 7 төсөл, арга хэмжээ, нийт 16 төсөл, арга хэмжээ төлөвлөн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийхдээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9 төсөл, арга хэмжээ, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 1 төсөл, арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар 7 төсөл, арга хэмжээ, нийт 17 төсөл, арга хэмжээ баталсан байна. Энэ нь анх баталсан ажлаас 3 ажлыг хасаж, 4 ажлыг нэмж баталсан байна. Үүнд:

/сая.төгрөг/

Д/д	Анх баталсан төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн	Тодотгол хийгдсэн төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн
1	Аймгийн авто зам дагуух замын цагдаагийн хяналтын 3 постын тохижилт	15.0	Аймгийн авто зам дагуух замын цагдаагийн хяналтын 3 постын тохижилт	15.0
2	Сагил суманд хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж авах	50.0	Сагил суманд хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж авах	50.0
3	Тариалан суманд ковш трактор авах	120.0	Тариалан суманд ковш трактор авах	120.0
4	Түргэн сумын зуслангийн замын эвдэрсэн хэсэгт засвар хийх	10.0	Түргэн сумын зуслангийн замын эвдэрсэн хэсэгт засвар хийх	10.0
5	Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх	487.2	Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх	487.2
6	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна авто зогсоол барих	48.0	Онцгой байдлын газарт автомашин авах	40.0
7	Улаангом сумын 2, 9, 10-р багт ухаалаг худаг	75.0	Онцгой байдлын газрын дэргэдэх Ковид-19 цар тахлын нөхцөлийн түр саатуулах байрны дэмжлэг	30.0
8	Улаангом сумын 6-р багт ухаалаг худаг	19.0	Цагдаагийн газрын явуулын пост	19.0
9			Мини захын дэнчинг "Ус рашаан эрдэнэ" ХХК-д буцаан олгох	18.6
	Нийт дүн	830.2	Нийт дүн	789.8

Хасагдсан төсөл, арга, хэмжээний хувьд:

- ❖ Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна авто зогсоол барих 48.0 сая төгрөгийн ажлыг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийхээр баталсан.
- ❖ Улаангом сумын 2, 9, 10-р багт ухаалаг худаг 75.0 сая, Улаангом сумын 6-р багт ухаалаг худаг 25.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг нэгтгэн 2, 6, 9-р багт ухаалаг худаг гаргах 135.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ болгон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийхээр баталсан байна. Анх төлөвлөсөн төсөвт өртөг хүрэлцээгүй шалтгаанаар 10-р багт ухаалаг худаг хийх төсөл, арга хэмжээг хассан байна.

Нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний хувьд:

- ❖ Онцгой байдлын газарт автомашин авах 40.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь Ковид-19 цар тахалтай холбоотой нэмэгджээ.
- ❖ Онцгой байдлын газрын дэргэдэх Ковид-19 цар тахлын нөхцөлийн түр саатуулах байрны дэмжлэг 30.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь Ковид-19 цар тахалтай холбоотой нэмэгджээ.
- ❖ Цагдаагийн газрын явуулын пост 19.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь Ковид-19 цар тахалтай холбоотой нэмэгджээ.
- ❖ Мини захын дэнчинг "Ус рашаан эрдэнэ" ХХК-д буцаан олгох 18.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь тайлангийн А.1.1-д тусгасан Шүүхийн шийдвэртэй холбоотойгоор нэмэгдсэн байна. Энэ төсөл, арга хэмжээ нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй байна.

А.1.3 Төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална”, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах төрөлтэй байна” гэж заажээ. Үүнд:

- 6.1.1 урт хугацааны;
- 6.1.2 дунд хугацааны;
- 6.1.3 богино хугацааны.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 3.2.1-д “төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх” гэж заажээ.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нийт сумдын болон Иргэдийн нийтийн хурлын болон холбогдох салбарын хэлтэс, агентлагийн саналыг авч аймгийн Хөгжлийн стратеги төлөвлөгөө /2008-2021/, Увс аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэ тогтоож, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан эрэмбэлж төлөвлөсөн байна.

А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлсэн ч хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.***А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 2 төсөл, арга хэмжээг төсөвлөж батлуулсан байна.***

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “Хөрөнгө оруулалтын төсөвлөлт”, 29.3 дахь хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана”, 29.3.1 дэх заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах”, 29.3.3 дахь заалтад “нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах”, 29.3.4 дэх заалтад “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах”, 29.3.5 дахь заалтад “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заажээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно”, 5.2.17 дахь заалтад “Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг” гэж заасан байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнүүдийг дээрх шаардлагын дагуу төлөвлөж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хангаагүй байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 17 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжаас ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах шаардлагатай АЗДТГ-ын өмнөх талбайгаас Бадрахын талбай хүртэлх талбайг сайжруулах, Бадрахын цэцэрлэгт хүрээлэнд жуулчдад үйлчлэх худалдааны орчин бүрдүүлэх, ногоон байгууламж, засвар тохижилт гэсэн 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг Орон нутгийн 2021 оны төсөв батлагдсаны дараа боловсруулж баталгаажуулжээ. Цаашид Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байхыг зөвлөмж болгов.

А.2.2 Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Төсвийн төслийн танилцуулгад дараах зүйлийг тусгана”, 32.2.6 дахь заалтад “Хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/ 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална”, 33.2.6 дахь заалтад “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/ гэж заажээ.

Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх 487.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хийгдэх зураг төсвийн ажлын нэр, байршил, төсөвт өртгийг задалж төлөвлөөгүй байна. Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний нэр, байршил, төсөвт өртгийг нэг бүрчлэн тусган төлөвлөж байхыг зөвлөмж болгов.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын 1,393.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэхээр тусгаж санхүүжилтийг баталсан нь хугацаандаа хэрэгжих боломжтойгоор төлөвлөгдсөн байна.

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1.1	Аймгийн авто зам дагуух замын цагдаагийн хяналтын 3 постын тохижилт	2021-2021	15.0	15.0
1.2	Сагил суманд хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж авах	2021-2021	50.0	50.0
1.3	Тариалан суманд ковш трактор авах	2021-2021	120.0	120.0
1.4	Түргэн сумын зуслангийн замын эвдэрсэн хэсэгт засвар хийх	2021-2021	10.0	10.0
1.5	Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх	2021-2021	487.2	487.2
1.6	Онцгой байдлын газарт автомашин авах	2021-2021	40.0	40.0
1.7	Онцгой байдлын газрын дэргэдэх Ковид-19 цар тахлын нөхцөлийн түр саатуулах байрны дэмжлэг	2021-2021	30.0	30.0
1.8	Цагдаагийн газрын явуулын пост	2021-2021	19.0	19.0
1.9	Мини захын дэнчинг "Ус рашаан эрдэнэ" ХХК-д буцаан олгох	2021-2021	18.6	18.6
	Нийт дүн		789.8	789.8

/Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол/

2. Аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1.1	АЗДТГ-ын өмнөх талбайгаас Бадрахын талбай хүртэлх талбайг сайжруулах ажил	2021-2021	345.0	345.0

/Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол/

3. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээ

/сая төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1.1	Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэх	2021-2021	20.0	20.0
1.2	Зэрлэг ан амьтдад зориулж биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх	2021-2021	10.0	10.0
1.3	Улаангом сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх	2021-2021	35.5	35.5
1.4	Бадрахын цэцэрлэгт хүрээлэнд жуулчдад үйлчлэх худалдааны орчин бүрдүүлэх, ногоон байгууламж, засвар тохижилтын ажил	2021-2021	138.0	138.0
1.5	Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгаа хийлгэж, агнуурын нөөц тогтоох	2021-2021	25.0	25.0

1.6	Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөц хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, нөхөрлөлийн менежмент төлөвлөгөөг боловсруулах	2021-2021	15.0	15.0
1.7	Ойн аж ахуйн арга хэмжээ зохион байгуулах, ойн үрийн талбай тусгаарлах, байгалийн сэргэн ургалтад туслах ажил	2021-2021	15.0	15.0
	Нийт дүн		258.5	258.5

/Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол/

А.2.3 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төсвийн тодотголоор төлөвлөж, батлуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх хэсэгт ““Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” хэлнэ гэж заасан байна.

Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.10.2 дахь заалтад “Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” гэж заажээ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан Мини захын дэнчинг “Ус рашаан Эрдэнэ” ХХК-д буцаан олгоход 18.6 сая төгрөг баталсан нь хөрөнгө оруулалтын шинж чанаргүй байна.

Цаашид хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байхыг зөвлөмж болгов.

БҮЛЭГ: 2. Гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.**Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулжээ.****Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, Сангийн сайдын 2019 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” -ын 2.13-д “Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон тохиолдолд батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасан байна.

Мөн Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг дараах байдлаар шилжүүлж болно”, 4.1.1-д “Төсвийн тухай хуулийн 14.4-д заасныг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн төвлөрүүлэн захирагчид, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг шилжүүлэх”, 4.1.2-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх” гэж заажээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 9 төсөл арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 7 төсөл арга хэмжээнээс 6 төсөл, арга хэмжээ, нийт 11 төсөл, арга хэмжээний эрхийг харьяалах Төсвийн төвлөрүүлэн захирагч болон Төсвийн шууд захирагч нарт шилжүүлсэн байна. Үүнд:

- *Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А/08 дугаар захирамжаар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2, Байгаль хамгаалах сангийн 4, нийт 6 төсөл, арга хэмжээг*
 1. Аймгийн авто зам дагуух замын цагдаагийн хяналтын 3 постын тохижилт
 2. Түргэн сумын зуслангийн замын эвдэрсэн хэсэгт засвар хийх
 3. Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэх
 4. Зэрлэг ан амьтдад зориулж биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх
 5. Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгаа хийлгэж, агнуурын нөөц тогтоох

6. Ойн аж ахуйн арга хэмжээ зохион байгуулах, ойн үрийн талбай тусгаарлах, байгалийн сэргэн ургалтад туслах ажил
- *Аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн А/251 дүгээр захирамжаар Байгаль хамгаалах сангийн 2 төсөл, арга хэмжээг*
 1. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөц хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, нөхөрлөлийн менежмент төлөвлөгөөг боловсруулах.
 2. Улаангом сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх /аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн А/234 дүгээр захирамжаар Улаангом сумын хог хаягдлын менежмент боловсруулах 15.5 сая, төвлөрсөн хог хаягдлын талбайг тэгшлэх, булах ажлын зардал 15.0 сая, Улаангом сумын хэмжээнд хашаандаа сайхан амьдрах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, бууруулах уралдаан зарлах 5.0 сая гэсэн 3 төсөл, арга хэмжээ болгосон байна.
 - *Аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/494 дүгээр захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээг*
 1. Онцгой байдлын газарт автомашин авах
 2. Онцгой байдлын газрын дэргэдэх Ковид-19 цар тахлын нөхцөлийн түр саатуулах байрны дэмжлэг
 3. Цагдаагийн газрын явуулын пост

Дээрх Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан байна.

Орон нутгийн өмчийн газар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 5 төсөл, арга хэмжээнд тендер худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг явуулахдаа 3 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалт, 1 төсөл арга хэмжээнд харьцуулалтын арга, 1 төсөл арга хэмжээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар зарласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар төсөл, арга хэмжээ бүрд үнэлгээний хороог томилсон байна.

Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж ирэхгүй хугацаа алдсанаас худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсан байна.

Үүнд:

- Үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн хугацааг нийт 5 төсөл, арга хэмжээнд 7-124 хоногоор хэтрүүлэн байгуулсан.
- Тендер зарлах хугацааг нийт 5 төсөл, арга хэмжээнд 30-70 хоногоор хэтрүүлэн зарласан байна.
- Гэрээ байгуулах эрх олгох хугацааг нийт 5 төсөл, арга хэмжээнд 92-162 хоногоор хэтрүүлэн байгуулсан байна.

Цаашид Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тендер сонгон шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулахыг зөвлөмж болгов.

Дараах 2 төсөл, арга хэмжээнд оролцогч материал ирүүлээгүй учраас 2 удаа тендер зарлаж хугацаа алдсан байна. Тухайлбал:

- Улаангом сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, 15.5 сая төгрөгийн ажилд 2 удаа
- Сагил суманд хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж авах, 50.0 сая төгрөгийн ажилд 2 удаа

Б.1.3. ХАА-г ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулсан байна.

Үнэлгээний хорооны гишүүд нь хууль тогтоомжид заасны дагуу тендерийн сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцохдоо ашиг сонирхлын урьдчилсан мэдэгдлийг мэдүүлсэн байна.

Орон нутгийн өмчийн газар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 5 төсөл, арга хэмжээнд тендер худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг явуулахдаа 3 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалт, 1 төсөл арга хэмжээнд харьцуулалтын арга, 1 төсөл арга хэмжээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар зарласан байна.

Цагдаагийн байгууллагад эрх шилжүүлсэн 2 төсөл, арга хэмжээ, Онцгой байдлын газарт эрх шилжүүлсэн 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт эрх шилжүүлсэн Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгаа хийлгэж, агнуурын нөөц тогтоох 24.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд харьцуулалтын аргаар тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно”, 34.1.5 дахь заалтад “Гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол” гэж заасан байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс шалтгаалан дараах төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Онцгой байдлын газрын дэргэдэх Ковид-19 цар тахлын нөхцөлийн түр саатуулах байрны дэмжлэг 30.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ,
- Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх 487.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр хийгдэх төсөл, арга хэмжээнүүдийн 21 зураг төсөв, 4 инженер геологийн судалгааны ажил

Орон нутгийн өмчийн газар Орон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим сайтад байршуулж, тендерийн урилгыг tender.gov.mn, Увс Орон нутгийн өмчийн газар [@UVS.ONUG](https://www.facebook.com/UVS.ONUG) хаяг, UVS.ONUG@G-mail цахим хаяг, MBC телевиз, Увс нам бус телевиз гэсэн орон

нутгийн телевиз болон Өглөөний сониноор олон нийтэд мэдээлсэн байна. Мөн 70453262 утсаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч ажилласан байна.

Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь заалтад “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана” гэж заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн өмчийн газраас Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг гаргаж 2022 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.2 Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн боловч гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлсэн боловч гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 9 төсөл арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн 6 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авсан нь зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдээс Ковид-19 цар тахал гарсан, гэрээний хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй байсан зэрэг шалтгаанаас болж 4 төсөл, арга хэмжээг 4-20 өдрөөр хэтрүүлэн хүлээлгэн өгсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 9 төсөл арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн 6 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд бүрэн олгосон байна. Ингэхдээ дараах 2 төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгасан байна.

- Сагил суманд хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж авах 50.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдөр 6 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулж, 6 дугаар сарын 29-ний өдөр 7 дугаар сарын 30-ны өдөр болгож, 8 дугаар сарын 5-ны өдөр 8 дугаар сарын 30-ны өдөр болгож, 9 дүгээр сарын 4-ний өдөр 9 дүгээр сарын 30-ны өдөр болгож гэрээний хугацааг 3 удаа сунгаж, 10 дугаар сарын 4-ний өдөр улсын комисс хүлээн авсан байна. Уг хугацаа сунгасан асуудал нь Ковид-19 цар тахлаас улмаас хил хааснаас шалтгаалжээ.
- Улаангом сумын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх ажилд багтсан Улаангом сумын хог хаягдлын менежмент боловсруулах 15.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний гэрээг 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр 9 дүгээр сарын 01-ний өдөр дуусахаар байгуулж, 9 дүгээр сарын 24-ний өдөр 10 дугаар сарын 10-ны өдөр болгож гэрээний хугацааг 1 удаа сунгаж, 10 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авсан байна. Уг хугацаа сунгасан асуудал нь Ковид-19 цар тахлаас улмаас хөл хорио тогтоосон, гэрээ удааширч байгуулагдсанаас шалтгаалжээ.

Харин гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй, гэрээний хугацааг сунгаагүй дараах 2 төсөл, арга хэмжээ байна.

- Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн аймгийн Засаг даргын тамгын газрын өмнөх талбайгаас Бадрахын талбай хүртэлх талбайг сайжруулах 344.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээ нь зураг төсөв батлагдаж ирээгүй хугацаа алдаж, ажил гүйцэтгэх гэрээг 9 дүгээр сарын 28-ны өдөр 10 дугаар сарын 20-ны өдөр дуусахаар байгуулсан боловч гэрээний хугацаанд дуусгаагүй байна.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгаа хийлгэж, агнуурын нөөц тогтоох 24.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээ нь уг менежментийн төлөвлөгөөний төслийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн дэмжүүлэн, Байгаль орчны яамаар батлуулах журамтай тул хүлээж аваагүй байна.

Цаашид гэрээний хугацаанд хийж дуусгаагүй барилга, байгууламжийг гүйцэтгэгч компаниар хийлгүүлэхийг зөвлөмж болгов.

Б.2.2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.1-д, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-д “Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгүүлж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.2 дахь заалт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.2 дахь заалтад “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.4-д заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана” гэж заасан байна.

Барилга хөгжлийн төвийн захирал аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 2021/43 дугаар “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-г байгуулан ажилласан байна.

Мөн аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 01/2021 дүгээр “Аймагт хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-г байгуулан ажилласан байна.

Гэрээний 1.4-д “Энэхүү гэрээ нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ” гэж заажээ. Цаашид гэрээг тайлант хугацааны эхэнд байгуулж байхыг зөвлөв.

Уг гэрээнд заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг үе шатны ажил болгон дээр хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж, чиглэл өгч ажиллажээ. Мөн төсөл, арга хэмжээнүүдэд аймгийн Засаг даргын улсын комисс ажиллуулах захирамж гарч ашиглалтад хүлээн авсан байна.

Б.2.3. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үе шат бүр дээр хийж ажилласан байна. Ингэдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу үе шатны ажил болгон дээр хяналт хийж ил далд ажлын актаар баталгаажуулжээ.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 15.3 дахь заалт болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.3 дахь заалтад “Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрд зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу зохиогчийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулсан байна.

Б.2.4 Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагч, зохиогч, хяналт тавих эрх бүхий мэргэжлийн байгууллагуудын хяналтыг тухай бүр хийж хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласныг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан байна.

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна.

Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 9 төсөл арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн 6 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд бүрэн олгосон байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн аймгийн Засаг даргын тамгын газрын өмнөх талбайгаас Бадрахын талбай хүртэлх талбайг сайжруулах 344.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлийг 42.5 хувь гэж

үнэлж 149.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, үлдэх санхүүжилт 197.9 сая төгрөгийг барилгын барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгаа хийлгэж, агнуурын нөөц тогтоох 24.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд бүрэн гүйцэтгэж тайлангийн төслийг ирүүлсэн боловч уг менежментийн төлөвлөгөөний төслийг журмын дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлээгүй, Байгаль орчны ямаар батлуулаагүй байсан тул тухайн ажлыг хүлээж аваагүй 17.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, үлдэх 7.4 сая төгрөгийн санхүүжилтийг барилгын барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Дээрх Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний үлдэгдэл 7.4 сая, аймгийн Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний үлдэгдэл 197.9 сая, нийт 205.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар бүлгийн 7.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт “Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 43.1.3-т зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн гурван хувиас хэтрэхгүй бөгөөд түүнээс давсан хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 43.5 дахь хэсэгт “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2 дахь заалтад “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл”, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байсанд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Барьцаа хөрөнгийн дансанд барьцаа хөрөнгө болон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үлдэгдлээс бусад төсөл, арга хэмжээний үлдэгдлийг төвлөрүүлэхгүй байх зөвлөмж өгсөн болно.

Б.3.2. Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгасан, улирлын байдлаас шалтгаалан зарим төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад

“Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасны дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 272.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн 136.2 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын явцад Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг газар дээр нь очиж биетээр үзэж, зураг авалт хийхэд улсын комисс ашиглалтад хүлээж авсан зарим төсөл, арга хэмжээ улирлын байдлаас шалтгаалан бүрэн хүчин чадлаар ашиглагдаж эхлээгүй байна. Тухайлбал:

- Бадрахын цэцэрлэгт хүрээлэнд жуулчдад үйлчлэх худалдааны орчин бүрдүүлэх, ногоон байгууламж, засвар тохижилтын ажил
- Сагил суманд хадлангийн зориулалттай тоног төхөөрөмж авах
- Тариалан суманд ковш трактор авах төсөл, арга хэмжээ

Б.4 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

/Сая төгрөгөөр/			
№	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Биелэлтийн хувь
1	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдыг томилж байх.	0.0	100%
2	Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй барилга, байгууламжийг гүйцэтгэгч компаниар хийлгүүлэх.	0.0	100%
3	Хийгдэх боломжгүй болсон “Улаангом сумын 8-р багт голын голдирол өөрчлөн суваг татах” ажлын санхүүжилт 4.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх.	4.0	100%

/Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын статистик бүртгэл/

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Гэрээний хугацаанд хийгдэж дуусаагүй 2 төсөл, арга хэмжээ байна.
2. ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 2 төсөл, арга хэмжээг төсөвлөж батлуулсан байна.
3. Шинээр төлөвлөж буй ажлын зураг төсөв хийлгэх 487.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хийгдэх зураг төсвийн ажлын нэр, байршил, төсөвт өртгийг задалж төлөвлөөгүй байна.
4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 1 төсөл, арга хэмжээг төсвийн тодотголоор батлуулсан байна.
5. Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт батлагдаж ирэхгүй хугацаа алдсанаас худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсан байна.
6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс шалтгаалан 1 төсөл, арга хэмжээ, 13 зураг төсөвт шууд худалдан авалт хийжээ.

Холбогдох байгууллагын санал


МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2315, Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2022.04.28 № 11738
танай 2022.04.26 -ны № 343 -т

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлтэй холбоотой дараах саналыг хүргүүлж байна.

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 28 дугаар магадлал, ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/77 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 оны төсвийн тодотгол хэлэлцэх явцад нэмэгдэж батлагдсаныг анхаарч үзэхийг хүсье.

Аудитын дүнд үндэслэн гаргасан зөвлөмжид дурдагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах болно.

Ч.ЧИМЭД

D disk: AZDTG- zasag A-5
8522020383



УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-3232, 7045-3262

Цахим шуудан: uvs.onug@gmail.com

Цахим хуудас: www.uvs.gov.mn/onug

2022.04.28 № 95

танай 2022.04.26 ны № 343 -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тендер сонгон шалгаруулалтыг Захиалагчаас ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөв ирүүлсэн даруйд зохион байгуулан ажиллаж байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТУХМ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



8822070019

**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 1/738 тоот, Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 95 тоот албан бичгүүдэд "... аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно" гэсэн хариу ирүүлсэн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөн батлуулах.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний нэр, байршил, төсөвт өртгийг нэг бүрчлэн тусган төлөвлөж байх.
3. Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл, арга хэмжээг төлөвлөн батлуулахгүй байх.

Аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:

4. Гэрээний хугацаанд хийж дуусгаагүй барилга, байгууламжийг гүйцэтгэгч компаниар хийлгүүлэх.

Орон нутгийн өмчийн газарт:

5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тендер сонгон шалгаруулалтыг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулах.

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

АУДИТОР

Б.ОДГЭРЭЛ

Т.АМАРМЭНД

